

**МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ТҮҮНИЙ
ОХИН КОМПАНИУД**
(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Нэгтгэсэн Санхүүгийн Хураангуй Тайлан
2023 оны 12 дугаар сарын 31

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МИК Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг МИК Холдинг ХК болон охин компаниуд (“Групп”)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Группын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Группын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэнд Аудитын онцгойлсон асуудлууд багтсан. Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт” байсан.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группын удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын олон улсын стандарт (“АОУС”) 810 буюу “Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил”-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.



Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Доржбатын Мандахбаяр
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 18

Баталсан



Вонг Шү Хинг
Партнер

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн****Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан**

	2023	2022
	мян.төг	мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	372,691,947	335,990,361
Хүүний зардал	(289,467,241)	(255,129,538)
Хүүний цэвэр орлого	83,224,706	80,860,823
Шимтгэл, хураамжийн зардал	(17,949,733)	(7,108,262)
Нийт үйл ажиллагааны орлого	65,274,973	73,752,561
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт/(зардал)	624,992	(11,786,965)
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгийн цэвэр олз/(гарз)	1,245,099	(2,629,610)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн цэвэр олз/(гарз)	(8,038,358)	115,877,409
Худалдан авсан орон сууцны зээлийн авлагын төлбөр хойшлуулсны алдагдал	–	(110,852,344)
Баталгаажсан бондын төлбөр хойшлуулсны олз	–	53,597,740
Нийт үйл ажиллагааны ашиг	59,106,706	117,958,791
Үйл ажиллагааны зардал	(17,188,289)	(16,755,433)
Бусад зардал	2,764,812	(90,766,919)
Татварын өмнөх ашиг	44,683,229	10,436,439
Орлогын албан татварын зардал	(16,569,573)	(4,432,831)
Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг	28,113,656	6,003,608
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)		
Нэгж хувьцаанд ногдох суурь болон шингэрүүлсэн ашиг	1,843.89	393.76

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн

Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан

	2023 мян.төг	2022 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах, хадгаламж	343,498,698	117,448,513
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	131,545,865	179,880,304
Буцаах нөхцөлтэй орон сууцны зээлийн багцын авлага	203,662,983	366,348,785
Буцаах нөхцөлтэй зээлийн багцын авлага	23,905,581	80,906,907
Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлага	4,082,796,161	3,432,162,229
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө	137,673,182	137,419,577
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	152,847,243	160,885,601
Бусад хөрөнгө	59,365,821	28,603,389
Үндсэн хөрөнгө	34,800,079	36,617,422
Биет бус хөрөнгө	260,948	247,996
Урьдчилж төлсөн орлогын албан татвар	190,620	1,318,076
Хойшлогдсон татварын хөрөнгө	9,619,187	12,883,280
НИЙТ ХӨРӨНГӨ	5,180,166,368	4,554,722,079
ӨР ТӨЛБӨР		
Бусад өр төлбөр	18,241,664	9,333,568
Зээлээр авсан эх үүсвэр	9,577,148	36,156,514
Өрийн үнэт цаас	760,736,859	819,963,304
Баталгаажсан бонд	4,317,570,902	3,648,483,325
Орлогын албан татварын өглөг	1,976,169	56,256
Хойшлогдсон татварын өр	33,799,834	30,578,976
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,141,902,576	4,544,571,943
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	20,709,320	20,709,320
Нэмэгдэж төлөгдсөн капитал	52,225,115	52,225,115
Халаасны хувьцаа	(62,143,136)	(62,143,136)
Нөөц	27,472,493	(641,163)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	38,263,792	10,150,136
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,180,166,368	4,554,722,079

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.